



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/65

Алтай хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн урсгал хөрөнгөөр “Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шатахуун нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Ж.Бодьгэрэл	-(“Гэгээн нуур-цэвэр ус” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга)
Гишүүд:	Б.Төртогтох	-(“Ундарга-Алтай” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч)
	М.Туул	-(Хөндлөнгийн төлөөлөл (тохиролцсон))
Нарийн бичиг:	Ц.Батсайхан	-(Есөнбулаг сумын иргэн)
	Ц.Анхбаяр	-(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг зохион байгуулан, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Ж.Бодьгэрэл)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Д.АЛТАНЗАГАС